

ХЯТАДЫН УЛС ТӨРИЙН ШИНЭТГЭЛ

*Н.Ариунгуа**

БНХАУ-д 1978 оноос өрнөж эхэлсэн зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явц Хятадын нийгэмд нааштай чухал өөрчлөлтүүдийг авчирхаас гадна мөн шийдвэрлэх шаардлагатай шинэ асуудлуудыг бий болгосон юм. Учир нь эдийн засгийн хувьд амжилтанд хүрсэн боловч нийгмийн салбарын хөгжлийн асуудлыг орхигдуулсан хийгээд шинэтгэлийн бодлогоо улс төрийн нөхцөл байдалтай сайн уялдуулаагүй зэрэг юм. Хятад улс шинэчлэлийн бодлогоо нийгмийн баримжаатай хэрэгжүүлэх зорилт тавьсан боловч өнөөгийн хятадын удирдлага нийгмийн салбарт шийдвэрлэгдээгүй маш олон асуудал байгааг хүлээн зөвшөөрөхөд хүрчээ. Хятадын нийгэмд өнөөдөр тулгараад байгаа бэрхшээлийг дурьдваас: ажилгүйдэл газар авсан, баян ядуугийн ялгаа ихэссэн, бүс нутгийн хөгжлийн ялгаа ихэсч улс орны нэгдмэл байдалд муугаар нөлөөлж байгаа, орон нутагт тодорхой эрх мэдэл олгосноор төвөөсөө хөндийрч, мужуудын түгжигдмэл байдал ихэсч, орон нутгийн үзэл газар авсан, нийгмийн ёс суртахуун доройтож хэв журам алдагдсан, хээл хахууль, хүнд суртал түгээмэл болсон, тариачдын амьдрал ядуу дорой хэвээр, татварын дарамт их зэрэг юм.¹ Дээрх хүчин зүйлүүдээс улбаалан хүн ардын дунд ХКН-ын нэр хүнд унах, ирээдүйдээ итгэх байдал алдрах хандлага ажиглагдаж байгаа ажээ. Эдгээр хүчин зүйлүүд нь цаашид даамжирвал нийгэм-улс төрийн хувьд тогтворгүй байдлыг үүсгэж болзошгүй учир ХКН өөрийн бодлогоо Хятад улсад үүсээд буй бодит байдалд нийцүүлэх шаардлагатай болоод байгаа юм. Ийнхүү эдийн засгийн шинэ нөхцөл байдалд ХКН-ын удирдлагын арга барилыг өөрчлөн шинэчлэх чухал асуудал тулгарч байгаа болно. ХКН энэ чиглэлээр зарим нэгэн өөрчлөлт хийж хуримтлуулсан туршлага дээрээ залруулга засвар хийх замаар аажим аажмаар урагшилж байна гэж хэлж болох юм. Улс төрийн системийн шинэтгэлийн асуудлыг анх Дэн Сяопин 1986 онд хөндсөн бөгөөд тэрээр “улс төрийн бүтцийн шинэтгэлийн талаар бидэнд тодорхой ойлголт одоогоор алга... Ямар ч байсан энэ чиглэлд бид харанхуйгаар урагшлах болох нь” гээд “Хятад шиг энэ том улсад улс төрийн системийг өөрчлөх явдал маш хэцүү асуудал бөгөөд түүнд хэрхэвч гоомой хандаж болохгүй, зөвхөн амжилтанд хүрнэ гэсэн нөхцөлд сая өөрчлөлт хийх шаардлагатай” хэмээсэн байдаг.²

ХКН-ын удирдлага аж ахуйн системийн өөрчлөлт нь улс төрийн механизмын өөрчлөлтийг заавал дагуулахыг ойлгож энэхүү чиглэлийн

* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

өөрчлөлтийг маш алгуур хийж эхэлсэн юм. Хятад улс ЗХУ задарсан явдлаас сургамж авсан бөгөөд Дэн Сяопин ЗХУ задарсны дараахан “зарим нэгэн /социалист/ орнууд хүнд байдалд орж социализм нилэнхүйдээ суларлаа. Гэвч бусдын гашуун туршлаган дээр суралцах хэрэгтэй бөгөөд чингэх нь социализмыг төгөлдөржүүлэх, эрүүлээр цаашид нь хөгжүүлэхэд тустай юм” гэжээ.³ Хятадын судлаачид ЗХУ-ын задарсан шалтгаан, Орос орны туршлагыг судлан дээрхи дүгнэлтэнд хүрсэн байх нь: Хятадын нийгмийг өөрчлөхдөө Орос орон шиг хэт зүүний үзлээс хэт барууны үзэл рүү түйлшрэх нь буруу гэжээ. Мөн намын үйл ажиллагаандаа ангийн тэмцэлд цагаа үрэн хүчээ тарамдуулахын оронд ард олонд тодорхой хэмжээнд ардчилал эрх чөлөө олгон, хээл хахууль, хүнд сурталтай тэмцэх замаар тэдний зүгээс дэмжлэг олох нь илүү үр дүнтэй. Чингэхдээ барууны орны жишгээр явах биш хятадын философи болох Күнзийн сургаалийг иш үндэс болгох нь шаардлагатай гэжээ.⁴

1987 онд ХКН-ын 13 их хурал улс төрийн шинэтгэлийн талаар тодорхой программыг дэвшүүлж улс төрийн бүтцэд хийх үндсэн чиглэлийг тодорхойлсон байх нь:

1. Нам төрийн үйл ажиллагааны үүргийг зааглах.
2. ХКН-ын нэгжүүдийн хэт төвлөрөлтийг сааруулах
3. БХАТИХ-ын институт хийгээд нам хоорондын хамтын ажиллагаа, улс төрийн яриа хэлэлцээний зарчмыг боловсронгуй болгох
4. Социалист хуулийг чангатгах
5. Намын ажлын арга барилыг сайжруулах
6. Нам доторхи ардчилалыг улс төрийн либералчилалтай хослуулах

Эдгээр заалтууд нь өнөө хүртэл хүчин төгөлдөр байгаа боловч зарим нэгэн залруулга, тодотгол хийгдсэн байгаа нь ХКН-ын удирдлагын арга барил бодлого нь эрэл хайгуулийн шатанд байгааг харуулж байгаа юм. Үүнийг Хятад улсын шинэ удирдлагуудын удаа дараа хэлсэн үгэнд шинэчлэлийг хийхдээ “алхам алхмаар” туршилтын журмаар хийх шаардлагатайг байнга сануулж байгаагаас харж болох юм.

Өнөөгийн шатанд Хятадын улс төрийн системд зарим нэгэн өөрчлөлт орсон бөгөөд тухайлбал ХКН-ын Дүрмэнд олон мандатын сонгуулийн системийг хүлээн зөвшөөрсөн мөн үйлдвэр аж ахуйн газрын намын байгуулагуудын зүгээс үйлдвэр аж ахуйн газрын ажилд хутгалдан оролцохыг хориглосон заалтууд орсон байна. Чингэхдээ дээрхи заалт нь зөвхөн орон нутгийн намын хороодын үйл ажиллагаанд хамааралтай бөгөөд харин дээд шатны нам засгийн

бүтцийн үйл ажиллагаанд хамаарагдахгүй ажээ. Гэвч сүүлийн үед нам, төрийн үүргийг зааглах гэсэн бодлого нь нам, төрийн байгууллагуудын харилцааг цэгцлэх, чингэхдээ намын зүгээс засгийн газрын үйл ажиллагаанд тавих үр өгөөжтэй системийг бий болгох бодлогоор солигдож буй нь ажиглагдаж байгаа юм.

Өнөөгийн шатанд Хятадын улс төрийн системийн өөрчлөлтийн онцлог бол юуны өмнө марксизм болон Мао Цзедуны үзлээр нэгэнт хязгаарлагдаж болохгүй болсон явдал юм. Энэ нь доорхи хүчин зүйлүүдээр тайлбарлагдана:

1. Дээрхи үзлүүд нь улс төр, эдийн засгийн хүрээнд хийгдэж буй бүтцийн чанартай өөрчлөлтийн асуудлуудыг шийдвэрлэхэд хангалтгүй.

2. Хятад улс нээлттэй гадаад улс төрийн бодлого хэрэгжүүлж байгаа

3. Зах зээлийн эдийн засгийн хөгжлийн явц түргэссэн

4. Бүх улсын хэмжээнд теле холбоо, зам тээвэр хөгжсөний улмаас мэдээлэл маш түргэн тархаж байгаа эдгээр юм.

Дээрхи хүчин зүйлүүд нь үзэл суртлын зарим өөрчлөлтийн хамт улс төрийн өөрчлөлтийн явцыг түргэсгэхийг шаардаж байгаа ажээ. Иймээс ч ерөнхий сайд Вэнь Зябао өөрийн толгойлсон засгийн газрын ажлын гол чиглэл бол улс төрийн системийн өөрчлөлт болно гэж мэдэгдээд байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор Хятадын засгийн газар 3 зүйлийн ажил хийхээр төлөвлөөд байна:

1. Эдийн засгийн чухал асуудлыг шийдвэрлэх ардчилсан механизмыг бүрдүүлэх

2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хуультай ягштал нийцүүлэх

3. Засгийн газрын үйл ажиллагааг БХАТИ-аар дамжуулан иргэний хяналтын системээр оруулдаг болгох

ХКН намын байгуулалтын асуудалд онцгой анхаарал тавьж байгаа бөгөөд энэ нь юуны өмнө нам доторхи ардчиллыг хөгжүүлэх, хяналтын бодлогыг хүчтэй болгох явдал юм. ХКН улс орныг удирдах үйл хэрэгт олон нийтийг хамруулах шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд чингэхдээ олон намын системийн хүрээнд бус засгийн эрх барьж буй намын нийгмийн баазыг өргөтгөх, нам хоорондын хамтын ажиллагаа, зөвшилцлийн практикийг өргөнөөр ашиглах замаар хэрэгжүүлэх ажээ. Үүнтэй холбоотой улс орны амин чухал асуудлыг хэлэлцэхдээ бусад намуудтай зөвшилцөх, хамтран ажиллах дүрэм журмыг тогтоосон байна. Энэ тухай 2005 оны 1-р сард гарсан “Олон намын хамтын ажиллагаа, зөвшилцлийг цаашид нэмэгдүүлэх талаар ХКН-ын Төв Хорооны үзэл баримтлал” хэмээх баримт бичигт тодорхой туссан байна. 1990 оны дунд үеэс Хятадын удирдлага улс орны чухал

асуудлаар шийдвэр гаргахдаа судлаач эрдэмтдийг татан оролцуулах болсон нь хуучин, үеэ өнгөрүүлсэн, үр өгөөжгүй аргачлал, шийдвэрээс ангижирч хөгжлийн шинэ бодлого бүрэлдэн бий болох үндсийг тавихын зэрэгцээ шийдвэрээ шинжлэх ухааны үндэслэлтэй болгох чухал хэлбэрийг сонгосон юм.

Өнөөдөр Хятад даяар улс төрийн шинэчлэлийн талаар маргаан ид өрнөж байгаа нь олон нийтийг улс орныг удирдах үйл хэрэгт татан оролцуулж буй жишээ юм. Энэ асуудлыг хэлэлцүүлэх явцад олон ургальч үзэл санаа, байр суурь илэрч байна. Тухайлбал Хятадын зарим улс төрчид ардчилалыг зөвхөн хятад онцлогтой социализмын хүрээнд авч үзэх нь учир дутагдалтай гэж байгаа бол зарим нь социализм бол ардчилалд хүрэх урьдчилсан нөхцөл гэж үзэж байна. Мөн даяарчлалын сайн муу талыг хөндөх, Хятадын нийгэмд үзүүлж буй энэхүү үйл явцын нөлөөг анхаарахгүй байж болохгүй гэсэн үзэл ч байгаа юм. Ямар ч байсан маргаанд оролцож буй хүмүүсийн дийлэнхи олонхи нь Хятадад улс төрийн системийн шинэтгэл яах аргагүй эдийн засгийн шинэчлэлийн явцаас хоцорч байгааг хүлээн зөвшөөрч байгаа юм. Учир нь Хятадад өрнөсөн эдийн засгийн шинэчлэл нь улс төрийн системийг өөрчилж чадаагүй бөгөөд түүнийг зөвхөн эдийн засгийн шинэ нөхцөл байдалд нийцүүлэх хэмжээнд хүргэсэн юм. Цаашдаа ч зарим гадны шинжээчдийн үзэж байгаагаар хэдийгээр Хятад улс улс төрийн системийн шинэтгэлийн талаар их ярьж байгаа боловч хэрэг дээрээ ХКН-ын социализм байгуулах стратеги өөрчлөгдөхгүй ажээ.

Боловсон хүчний бодлого бол нам төрийн үүрэг хамгийн эхээр холилдсон чингэхдээ намын үүрэг зонхилж буй салбаруудын нэг гэж хэлж болно. Иймээс сүүлийн үед Хятадын улс төрийн системд зохион байгуулалтын зарим нэгэн өөрчлөлт орсон нь дээд албан тушаалын боловсон хүчнийг сонгох замаар ажилд томилох зарчим бөгөөд энэ нь нэг хүний ганцаар ноёрхох байдлыг өөрчлөх зорилготой ажээ. Үүнтэй холбоотой “Гурван үеийн төлөөлөгч” Хятадын төрд байх ёстой гэсэн үзэл баримтлалыг хүчтэй өрнүүлж Үндсэн хуулиндаа мөн заалт болгон оруулсан юм. Иймээс зарим хятад судлаачид социализмын түүхэнд анх удаа засаг төрийн удирдлага солигдох хууль зүйн механизм бүрэн утгаараа хэрэгжих найдвар төрж байна гэж үзэж байгаа юм.⁵ Хэдий тийм боловч дээд удирдлагын залгамж чанарыг институтчилах шаардлагатай ч мөн цохон тэмдэглэж байгаа бөгөөд энэ нь төрийн тогтвортой байдлыг хангах гол хүчин зүйл ажээ. Дэн Сяопин улс төрийг зангидагч гол хүнгүй төр залгамж чанар, нэгдсэн байдлаа алдах аюултай хэмээн үзэж байжээ. Иймээс төрийн залгамж чанар, удаан хугацааны тогтвортой байдлыг хангах үүднээс улс төрийн лидер шаардлагатай гэжээ. Хятад улсад төрийн удирдлагын

залгамжийг бэлтгэх ажил урьдчилсан төлөвлөгөөтэй, тодорхой зорилготой хэрэгждэг байна.⁶ Энэхүү улс төрийн практик хэрэгжиж байгаа явдлыг зарим судлаачид Хятад улс түүхнээсээ эзэн хааны дээд эрхэнд захирагдаж байсан уламжлалаар тайлбарладаг тал ч байдаг.

Сүүлийн үеийн байдлаас харахад ХКН-ын гишүүнчлэлийн нийгмийн баазыг өөрчлөх хандлага гарч байна. Үүний нэг илрэл бол ХКН-ын эгнээнд хувиараа бизнес эрхлэгчдийг элсүүлж байгаа явдал юм. ХКН-ын дотор өөрчлөлт хийхэд залуучуудын улс төржсөн бүлэг ихэд шаардагдаж байгаа ажээ. Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсон явдал Хятадын хүн амын дотор барууны нөлөө ихэхсэд түлхэц өгөх нь дамжиггүй. Мөн олон тооны оюутнууд барууны орнуудад суралцаж байгаа бөгөөд энэ сувгаар барууны нөлөө орж ирсээр байх болно. Нөгөөтэйгүүр интернет ч маш том суваг болох нь зайлшгүй юм. Сүүлийн үед хятадын эрдэмтэд нийгэм –эдийн засгийн шилжилтийн үеийн сөргөлдөөн ба төрийн удаан хугацааны тогтвортой байдлыг хангах талаар судалгаа хийж санал бодлоо дэвшүүлж байна. Тухайлбал хятадын судлаач Liu Neng “Socio-economic Transition, Conflict and Government in China”⁷ хэмээх өгүүлэлдээ хэвлэлийн ил тод системийг бий болгох шаардлагыг заахын хамт олон нийт төрөөс зохион явуулж буй ажлын талаар өргөн мэдээлэлтэй байх эрхтэй тухай бичсэн байна. Мөн төрийн бус байгууллагууд нь нийгэм улс төрийн системийг боловсронгуй болгоход чухал үүрэгтэй гээд тэдгээр байгууллагууд нь тухайлбал төрийн бус бизнесийн бүлэг, ассоциаци, зуучлагч байгууллагууд нь төр, олон нийтийн хооронд гүүр болж өгөх боломжтойг дурьдсан байна.

1982 оны үндсэн хуулинд хувийн өмч, хүний эрхийг хамгаалах заалтыг нэмж оруулсан байна. Энэхүү заалтыг БХАТИХ-ын 10 дахь удаагийн 3 дахь чуулганаар /2004 оны 3-р сарын 5-14/ баталсан бөгөөд энэ асуудлаар санал хураахад 2863 депутат дэмжиж, 10 нь татгалзаж, 17 хүн түдгэлзсэн байдаг. Дээрхи өөрчлөлт нь гол төлөв эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор хийгдэж байгаа бөгөөд ХКН-ын эгнээнд бизнесийхнийг өргөнөөр татаж оруулах сонирхолтой байгаа нь хятад маягийн ардчилалын замаар цаашид хөгжинө гэсэн үг юм гэж барууны шинжээчид үзэж байна. Хүний эрхийн хувьд гэвэл Хятад улс өөрийн гэсэн ойлголттой бөгөөд хятадын судлаачдын тайлбарлаж байгаагаар Хятадын төр улсын түүхийн хөгжлийн онцлогтой холбоотой ажээ. Шинэ үеийн түүхийн явцад Хятад улсын тусгаар тогтнол байнга алдагдаж байсан учир улс орны тусгаар тогтнол хятадын уламжлалт оюун санааны үнэт зүйлсийн хувьд хамгийн эрхэм зүйл ажээ. Өөрөөр хэлбэл “тусгаар тогтнол баймаажин сая хүний эрх байх” учир хүний эрхийг улс үндэстний эрхээс дээгүүр тавьж

болохгүй гэсэн санаа ажээ. Иймээс өнөөдөр Хятадад “нийтийн /хүний/ эрх” гэсэн үзэл баримтлалыг маш өргөнөөр сурталчилж байгаа бөгөөд энэ нь олон хүний нийтлэг эрх нь /улс орны эрх ашиг/ ганц хүний эрхээс дээгүүр гэсэн санааг илэрхийлж байна.⁸ Энд тэмдэглэхэд энэхүү үзэл баримтлалыг мөн ОХУ-ын зарим нэгэн дээд удирдлагын хэлсэн үгэнд дурьдагдах болсон бөгөөд үүнийгээ тэд “суверенная демократия” гэж томъёолж байгаа юм. Хятад улс хүний эрхийн талаар хатуу байр суурь баримталдаг бөгөөд барууны орнуудын зүгээс хүний эрхийн асуудлыг олон улсын харилцааг зохицуулах шалгуур зарчим болгож байгааг эсэргүүцсээр байгаа юм.

Сүүлийн үед ХКН-ын үзэл суртлын баазыг шинэчлэх хандлага бий болсон нь өнөөгийн Хятадын нийгэм-улс төрийн хөгжлийн бодит шаардлагаас урган гарч ирсэн гэж хэлж болох юм. Үзэл суртлын шинэчлэл болох “үндэсний оюун санаа” /үндэс угсаагаа гэсэн үзэл/ гэсэн ойлголт анх ХКН-ын 16 Их Хурал дээр томъёлогдон цаашид хүн ардын дунд энэхүү үзэл санааны утга учир, ач холбогдлыг сурталчилах ажил өрнөж төрийн чухал бичиг баримтанд ч тусгалаа олсон юм. Тухайлбал Ардын төлөөлөгчдийн улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн дүрмэнд /2004/ “үндэсний оюун санаа”-г дээдлэн нэвтрүүлэх талаар заалт орсон бөгөөд чингэх нь стратегийн чухал зорилт гэж заасан нь энэхүү үзэл баримтлал Хятад улсын цаашдын хөгжилд ямар их ач холбогдолтойг харуулж байгаа юм. Юуны өмнө энэхүү үзэл санаа нь ард түмэн, улс орныг нэгтгэн нягтруулахад чухал ач холбогдолтойн сацуу улс орны хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай ажээ. Мөн үндэсний оюун санааны тулгуур баганы хувьд улс орны хөгжлийг хангахаас гадна улсын тогтвортой байдлыг бий болгох чухал хүчин зүйл гэжээ .

“Үндэсний оюун санаа” гэсэн үзэл баримтлал нь явцуу үндсэрхэг үзлээс эрс ялгаатай, “гол цөм” нь эх оронч үзэл гэж тайлбарлаж байгаа бөгөөд нөгөөтэйгүүр хятадын уламжлалт соёлын нийлбэр учир үүнийг боловсролын системийн бүхий л шатны программанд /цэцэрлэгийн хүмүүжлийн программаас эхлэн/ нэвтрүүлэх, мөн уран зохиол, кино урлаг, телевизийн нэвтрүүлэг, хөгжим дуу бүжигт тусгахын чухлыг зааж байгаа юм. Энэхүү үзэл суртлын шинэчлэл нь Хятад улсыг нэгтгэн нягтруулах шаардлагаас үүдэн гарсан бөгөөд улс орны шинэчлэлийн программыг эрчимжүүлэх мөн Хятад улсын бүрэн бүтэн байдлыг хангах зорилготой юм.

Ийнхүү Хятад улс улс төрийн шинэчлэлийг аажим аажмаар хийж эхлээд байгаа бөгөөд энэ нь цаашид нийгэм –эдийн засгийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд чухал хүчин зүйл юм.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. He Qinglian. China is Listing Social Structure// New Left Review. London 2000, №5. P.68/
2. Дэн Сяопин. Основные вопросы современного Китая. М., 1988. с.192, 194
3. Кристофер Марш. Распад Советского Союза и проблемы новой России: уроки для Китая С.141
4. Дээрхи зохиол Т.143
5. Н.Мамаева КПК на современном этапе развития. Проблемы Дальнего Востока. 2006, №2, с.51
6. Лопатина.А Проблема преемственности в КНР: размышления после 16-го съезда КПК //Азия-2002: новые тенденции в экономике и внешней политике. М.: ИМЭПИ РАН, 2003. с.22/
7. Liu Neng. “Socio-economic Transition, Conflict and Government in China” /State and Civil Society in the Context of Transition. Beijing, 2005, 128 p/
8. Сяо Гуннцинъ. Хятад болон АНУ-ын улс төрийн соёлын эрс тэрс байдлыг шинжилэхүй – Жанлюэ юй гуанъли /Стратеги ба удирдлага/ Бээжин 2001, №2 т.39/